



Б.Тунгалаг
МУБИС-ийн НХУС-ийн Гадаад хэлний төвийн багш, дэд профессор

БАГШ БЭЛТГЭХ СУРГУУЛЬД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

Abstract: The preparation, recruitment, and retention of teachers are coherently interrelated, but typically there is no policy framework that links them together in a coherent fashion and that is connected to national and state educational goals and standards. Basically, the paper intends to present how students are selected and admitted to pre-service teacher education institutions in the highly developed countries and to find better ways to adopt or disseminate best practices into Mongolian national context of teacher preparation.

Key words: student selection criteria and requirements to teacher education institutions

Оршил

Багш бэлтгэх хөтөлбөрийн цөм хэсэг нь багшлах авьяас, сонирхолтой хүүхдийг өндөр шалгуураар сонгон шалгаруулж, элсүүлэх явдал юм. Багш мэргэжлээр оюутан элсүүлэх, багш бэлтгэх тогтолцоо, багш мэргэжлээр төгсөгчдөд "багшлах эрх олгох", багшийг ажилд авах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах зэрэг нь хоорондоо нягт уялдаа холбоотой зүйл юм. Харин энэ бүхнийг нэгдмэл цогц байдлаар авч үзсэн, улс үндэстэн, олон улсын болоод дэлхийн хэмжээнд хэрэгжүүлж мөрдөх зорилго, стандарт бүхий цогц бодлогыг цэгцлэн боловсруулж хараахан гаргаагүй байгаа [UNESCO Education Policy Series, 2006].

Багш мэргэжлээр оюутан элсүүлэх, багш бэлтгэх, багшийг ажилд авах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах зэрэг нь өөр хоорондоо нягт уялдаа холбоотой асуудал юм. Хөгжиж буй орнуудад багшийн нийгэмд эзлэх байр суурь тогтворгүй, энэ мэргэжлийн нэр хүндийг өсгөх тусгайлсан бодлого хэрэгжүүлдэггүйтэй уялдан багш мэргэжлээр элсэгчдийн тоо болон шинээр бэлтгэгдэж байгаа багшийн тоог хүн амын тоотой нь харьцуулахад харьцангуй бага байдаг ажээ. Харин Барууны орнуудад багшийг

олноор бэлтгэдэг боловч төгсөгчдийн ихэнх нь багш мэргэжлээр ажилладаггүй, өөр салбарт ажиллахыг илүүд үздэг хандлагатай байна. Тухайлбал, АНУ-д багш мэргэжлээр төгсөгчдийн 60% нь багшаар ажилладаг байхад Их Британи улсад төгсөгчдийн 40% нь багшаар ажиллаад эхний гурван жилдээ ажлаа орхидог байна. Харин Герман, Франц, Хонконг, Португал зэрэг оронд ийм асуудал гардаггүй ажээ.

Дээрх чиглэлээр хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад ихэнх улс орнууд багшийн хангамжийн асуудалд их анхаарал хандуулаад, сургалтын материаллаг орчныг бүрдүүлэх тал дээр нэлээд дутагдалтай ажиллаж иржээ. Өөрөөр хэлбэл, багш бэлтгэх тогтолцоог сайжруулах, багшлах эрх олгох буюу лицензжүүлэх, багш мэргэжлээр элсэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор тэтгэлэг олгох, багшийн цалинг нэмэх зэргээр багшийн мэргэжлийн нэр хүндийг өсгөх талаар олон талт үйл ажиллагааг амжилттай явуулж иржээ. Хэдий тийм боловч сургууль, цэцэрлэгийн сургалтын орчныг сайжруулах талаар харьцангуй бага зүйлийг хийснийг судалгааны дүн харуулж байна. Энэ нь эргээд "багш мэргэжлийн континиум (teacher's career continuum)" -ыг үндэсний болоод орон нутгийн хэмжээнд боловсролын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн тогтолцоотой уялдуулахад учир дутагдалтай болж ирсэн байна [UNESCO Education Policy Series, 2006:4-5].

Дэлхийн ихэнх улс орнууд боловсролын "төвлөрөөгүй тогтолцоо"-г хэрэгжүүлэхэд хүрч, нэлээд бэрхшээлтэй тулгарчээ. Иймд улс орон бүр багш мэргэжлээр оюутан элсүүлэх, багш бэлтгэх, багшийг ажилд авах улмаар тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах зэрэг асуудлын талаар нэгдмэл ойлголтонд хүрэхийг зорьж, өөр өөрийн оронд тулгарч буй бэрхшээлд тулгуурлан цогц бодлого авч хэрэгжүүлэхийг хичээж иржээ.



Бид энэ удаад дээрх олон тулгамдсан асуудлыг нэгэн зэрэг хөндөхийг хүсэлгүй, зөвхөн багш мэргэжлээр оюутан элсүүлдэг олон улсын туршлагыг судлан тодруулахыг зорив.

Багш мэргэжлээр элсэгчдэд тавих ерөнхий шаардлага

Дэлхийд боловсролоор тэргүүлэгч улс орнуудад багш мэргэжлээр элсэгчдэд тавих ерөнхий шаардлага байдаг ажээ. Тэдгээрээс үлгэр болгож хэдэн улсыг тусгайлан авч үзье.

АНУ-ын ихэнх мужуудад багшлах авьяас, сонирхолтой хүүхдийн оюун чадварыг илүүд үзэхээс гадна тухайн хүнийг сурган хүмүүжүүлэгч-багш болоход бүрэн бэлтгэгдсэн, эсэхийг шалгадаг байна. Хэдийгээр муж бүр өөр өөрийн онцлогийг харгалзсан багш мэргэжлээр элсэх журам, тогтолцоог баримталдаг ч АНУ-ын ихэнх буюу 40 гаруй мужид сурагчдыг коллежийн түвшний багш бэлтгэх хөтөлбөрт элсүүлэх ерөнхий шаардлага бол Боловсролын Үнэлгээний Газар (Educational Testing Service)-аас гаргасан Чадварын сорил буюу (Praxis I - Pre-Professional Skills Tests PPST) Праксис-1 сорилд тэнцсэн байхыг шаарддаг байна.

Англи улсын багш бэлтгэх хөтөлбөрүүд нь маш өрсөлдөөнтэй байдаг. Багш мэргэжлээр элсэгчид нь багшийн мэргэжилд тавигдах доод шаардлага болон тухайн жил элсэгчдэд тавих бүх ерөнхий шаардлагыг хангасан байх ёстой. Мөн түүнчлэн элсэгч нь өөрийн бүх талын авьяас, ур чадвар, хүүхэдтэй харьцах эв дүй, туршлагыг харуулах ёстой байдаг. Эдгээр авьяас, ур чадварт тухайн элсэгчийн сургалтын орчинд бусадтай хамтран ажиллах, бүлгийн ажилд амжилттай оролцох чадвар, идэвхтэй харилцааны арга барил, сургууль, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох туршлага, мөн асуудал шийдвэрлэх чадвар зэргийг оруулдаг байна. Багш мэргэжлээр элсэгч нь дараах шаардлагыг заавал биелүүлэх ёстой. Тэр нь

1. Бичгийн болон ярианы англи хэлийг маш сайн сурсан байх, өөрөөр хэлбэл, англи хэлний шалгалтад "C" үнэлгээнээс дээш авсан байх

2. Математикийн шалгалтад "C" үнэлгээнээс дээш авсан байх

3. Дунд боловсролын гэрчилгээ олгох ерөнхий шалгалтад тэнцсэн байх зэрэг юм.

Сингапур улс бол сурагчдын багшлах авьяас сонирхлыг тогтоож, хөгжүүлэхэд маш оновчтой, ойлгомжтой арга хандлагыг хэрэглэж ирсэн арвин туршлагатай юм. Боловсролын хүртээмжийг дээшлүүлж, чанартай боловсрол олгохын (түгээхийн) тулд багшлах боловсон хүчнийг чадавхжуулах асуудлыг чухалчлан анхаарч иржээ. Ингэхдээ юуны өмнө 1. Багшлах авьяас, сонирхолтой хүүхдийг сонгон шалгаруулах, 2. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх, 3. Сургаж бэлтгэх, 4. Тэтгэлэг болон нөхөн олговор олгох,

5. Багш бэлтгэх сургуулийн багшлах боловсон хүчнийг хөгжүүлэх гэсэн "багц тогтолцоо"-г боловсруулан хэрэгжүүлж ирсэн уламжлалтай.

Сингапур улсад "эхлээд багш болох хүүхдийг сонго, дараа нь сургаж бэлтгэ" гэсэн зарчмыг чандлан баримталж ирсэн ажээ. Иймд багшлах авьяас, сонирхолтой хүүхдийг дунд сургууль төгссөн нийт сурагчдын гуравны нэгээс сургуулийн удирдлага, багш нарыг оролцуулан маш өндөр шалгуураар сонгон шалгаруулж авдаг байна.

Багш бэлтгэх бакалаврын сургалтын хөтөлбөрийн гол зорилго нь элсэгчдийг сургалт, эрдэм шинжилгээний болон мэргэжлийн ур чадварын хөгжлийг дээшлүүлэхэд чиглэсэн арга зүйн зөвлөмжөөр хангахад чиглэгдсэн байдаг ажээ.

Финланд улсад боловсролын салбарт тулгараад байгаа бэрхшээлийг шийдвэрлэх хамгийн сонгомол бөгөөд шилдэг гарц бол багш бэлтгэх сургуульд оюутан элсүүлэх стандартыг сайжруулж, чанаржуулах, багшийн хүлээх үүрэг хариуцлагыг өндөржүүлэх явдал гэж үздэг. Учир нь тэд "...багшлахуй гэдэг нь "эрэлхийлсний дараа хийх ажил" юм, харин "багш хүн гэдэг бол "үйлийн судлаач" байх ёстой" хэмээн ойлгодог байна.

Иймээс Финланд улс багшийн нийгэмд эзлэх байр суурийг өсгөж, эрдмийн зэрэг, цолыг үл харгалзан их, дээд, бага, дунд, сургуулийн өмнөх гэсэн бүх шатны боловсролын байгууллагад ажиллаж буй багш нарыг "багш" хэмээн адил тэгш нэрлэнэ гэж тунхаглан зарлажээ.

Финланд улсын Засгийн газраас багшийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд ихэд анхаардаг бөгөөд тэдэнд итгэх итгэл үнэмшлийг төрүүлэх, хүндэтгэл үзүүлэх, ажиллах орчин нөхцөлийг нь сайжруулах замаар багшийн мэргэжлийн нэр хүндийг өндөрт өргөдөг байна. Оюунлаг, мэргэжлийн ур чадвар сайтай "сайн" багшийг бэлтгэх эхний үе шат бол сонгон шалгаруулалт гэж үздэг. Тиймээс Финланд улсад багшийн мэргэжил хамгийн нэр хүндтэй бөгөөд эрэлттэй байдаг ажээ. Нэгэн жишээ дурдахад, 2010 онд бага боловсролын 660 багшийн орон тоон дээр 6600 оюутан өрсөлдсөн нь үүний нэг илрэл юм.

Энэтхэг улсад боловсролын чанарыг сайжруулахад багшийн гүйцэтгэх үүрэг, тэдний сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны эцсийн үр дүн болох "төлөвшсөн иргэн" хүнийг бэлтгэх хамгаас чухал гэж үздэг [4:18]. Өөрөөр хэлбэл, "төлөвшсөн дэлхийн иргэн"-ийг бэлтгэх эхний том алхам бол багш бэлтгэх сургуульд оюутан элсүүлэх, сонгон шалгаруулах үйл явц, элсэлтийн журам хэмээн үздэг байна [8:48].

Тиймээс багш бэлтгэх их, дээд сургуульд оюутан элсүүлэх сонгон шалгаруулалтыг чанаржуулах талаар янз бүрийн судалгаа хийж, үр дүнг нь сургалтын үйл явц, үр дүнтэй

уялдуулахыг хичээж иржээ. Тухайлбал, Махариш Даянанд Их Сургууль, Жай Нараян Уяас их Сургуулиудын профессорууд “Багш мэргэжлээр элсэгчдэд зориулсан сорил” боловсруулсан бөгөөд уг сорилыг тухайн жилд ахлах сургуулиа төгсөж буй 17 настай сурагчид бөглөх ёстой. Ийм байдлаар багш мэргэжлээр “тохиолдлын” хүн суралцах явдлыг зогсоож, зөвхөн өөрөө хүссэн, бас тодорхой чадвартай хүмүүсийг элсүүлэхийг гол зорилгоо болгодог ажээ.

Багш мэргэжлээр элсэгчдэд тавих тусгай шаардлага

Дээрх улс орнуудад багш мэргэжлээр суралцагчдад авьяас ба чадварын ерөнхий шаардлагын зэрэгцээ бас тусгай шаардлага тавьдаг юм байна.

Англи улсад багш болох сурагчдад тавигдах ерөнхий шаардлагаас гадна дахин 8 тусгай шаардлага тавьдаг ажээ. Тэдгээр нь

1. Багшийн ёсзүйн хэм хэмжээг эзэмшсэн байдал, зан авир нь багш болоход тохирох, эсэхийг нотолсон байх. Багш мэргэжлээр элсэгч нь мэргэжлийн болоод оюутан, олон нийттэй харилцах стандартыг чандлан дагаж мөрдөх ёстой гэдгийг маш сайн ухамсарлаж ойлгосон байхыг шаарддаг. Багш хүн гэдэг бол оюутандаа үлгэр жишээ болохуйц, хууль бус зүйлийг хийхгүй тэвчих чадвартай байх ёстой хэмээн үздэг. Өөрөөр хэлбэл, багш мэргэжлээр элсэгч нь янз бүрийн гэмт хэрэг үйлдэхгүй, хууль зөрчихгүй байна гэсэн тангараг өргөх ёстой.

2. Хүүхэдтэй харьцах эв дүй, сурган хүмүүжүүлэх туршлага. Сайн багш нар хүүхэд, эцэг эхтэй харьцах болон сургуулийн үйл ажиллагаанд оролцох маш их туршлагатай байдаг гэж үздэг. Багш мэргэжлээр элсэгчийн хүүхэдтэй харьцах эв дүй, сурган хүмүүжүүлэх туршлагыг тоон үзүүлэлтээр хэмжихээс гадна чанарын үзүүлэлтийг ихэд чухалчлан үздэг байна. Зарим багш бэлтгэх хөтөлбөрүүд нь тухайн элсэгчээс тусгай ур чадвар, туршлагыг эзэмшсэн байхыг шаарддаг.

3. Ярилцлага болон бусад шалгуурууд. Элсэгч нь элсэлтийн ярилцлаганд заавал орсон байх ёстой. Ярилцлагын явцад комисс нь тухайн элсэгчийг багш бэлтгэх сургуульд элсүүлэх эцсийн шийдвэрийг гаргахад шаардлагатай нэмэлт мэдээллийг олж авахыг зорьдог.

4. Шалгалтын журам. Багш мэргэжлээр элсэх бүх оюутнууд стандарт сорилыг заавал өгсөн байх ёстой.

5. Багш бэлтгэх сургуулийн элсэлтийн журам, стандартыг бүрэн хангасан байх

6. Хувийн танилцуулга, мэргэжлийн болон ур чадварыг илэрхийлсэн тодорхойлолт, хувийн сэдлийг илэрхийлсэн лавлагаа, түүнчлэн тухайн элсэгчийн нийгэм, соёлын талаарх мэдлэг

7. Өөрийн сонирхсон мэргэшлийн талаар

маш өргөн ойлголттой, хүсэл тэмүүлэл, сонирхолтой байх, сэтгэлгээ, үзэл бодлын хувьд чөлөөтэй, илэн далангүй байх.

8. Тухайн мэргэжилд тавигдах шаардлагыг ухамсарлаж ойлгосон байх. Жишээлбэл, сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр бакалаврын зэргийн сургалтад хамрагдахыг хүссэн элсэгч нь дараах мэдлэг, чадварыг эзэмшсэн байх шаардлагатай байна. Үүнд,

- Бага насны хүүхдийн сурган хүмүүжүүлэх зүй, сэтгэл судлалын талаарх тодорхой ойлголттой байх
- Нийгмийн болон соёлын мэдлэгийг дээшлүүлсэн байх
- Хариуцлага хүлээх чадвартай байх
- Судалгаа, эрдэм шинжилгээний тодорхой үйл ажиллагаанд оролцсон байх
- Эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн салбарт боловсролын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, жишээ нь, хүүхэд, залуучууд, тэдний гэр бүл хамтран ажиллах бололцоог бий болгох зэрэг юм.

Сингапур улсад доорх 3 нэмэлт шаардлага тавьдаг ажээ. Тэдгээр нь

1. Судалгааны чадвар ба үүрэг хариуцлагатай байх (academic ability and commitment)

2. Багшлах авьяас сонирхолтой сурагчдыг багшлуулж, дадлага хийлгэсэн байх

3. Бодит ахуйд дасан зохицох чадвартай байх, тодруулж хэлбэл, хүүхэдтэй харьцах эв дүй, туршлагатай байх зэрэг юм.

Финланд улсад багш болох хүнд дор дурдсан 5 шаардлагыг тавьдаг байна. Тэр нь

1. Финланд улсын боловсролын эрхэм зорилгыг хүндлэн дээдлэх сэтгэлтэй, хүмүүжилтэй иргэн байх,

2. Хүнлэг энэрэнгүй, эх оронч, арвич хямгач байх,

3. Өөрийн үүрэг хариуцлагаа ухамсарлан ойлгох мэдрэмжтэй байх,

4. Бусдыг сайн сайхан амьдрахад боломж олгоход бэлэн, үүнд суралцсан байх,

5. Боловсрол, хүний хөгжлийн талаар мэдлэгтэй байхаас гадна “судлаач, дадлагажигч” байх зэрэг ажээ.

Багш мэргэжлээр элсэгчдээс авах шалгалт

Дэлхийн ихэнх улсуудад багш мэргэжлээр элсэгчдээс авах тусгай шалгалт гэж байдаггүй, бусад шалгалтын адил нэгдсэн журмаар авдаг. Харин боловсролоор тэргүүлэгч улсуудад багшийн мэргэжлээр элсэгчдээс авах шалгалт бусад мэргэжлээс өөр тусгай байдаг ажээ.

Австри улсад багш мэргэжлээр элсэхийг хүссэн бүх оюутнаас авах шалгалтын агуулга нь



дараах хэсгээс бүрддэг байна.

1. Ерөнхий сэдэвтэй бичгийн ажил
2. Сонгосон мэргэжлийн чиглэлээрээ суралцахад шаардагдах чадвар болон өмнөх сургалтаар олж авсан мэдлэгтэй уялдаатай шалгалтын 3 хэсэг (заавал судлах хичээлээс)
3. Дараах хэсгээс сонгон шалгалт өгнө.
 - Өөрийн мэргэшихийг хүссэн чиглэл,
 - Өөрийн сонгосон мэргэжилд тавигдах урьдчилсан шалгуур,
 - Багш мэргэжлээр суралцахад шаардагдах мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой сонгон судалсан хичээлүүд ажээ.

Элсэгч нь ерөнхий сэдэвтэй бичгийн ажлаар өөрийн үзэл бодлыг тодорхой илэрхийлэх, хэл бичгийн соёл хэрхэн эзэмшсэнийг илтгэн харуулна. Бичгийн ажил хийхдээ дараах 3 сэдвээс сонгон 4 цагийн хооронд бичнэ. Тэр нь

1. Австрийн түүхийн онцлог
2. Австри улсын өнөөгийн байдал
3. Австри улсын дэлхийд эзлэх байр суурь зэрэг ажээ. Энэ шалгалтад тэнцвэл багш мэргэжлээр сурах эрхтэй болно.

ХБНГУ-ын их, дээд сургуульд элсэх хүсэлт гаргахад тухайн сурагч нь гимнази төгсөх аман болон бичгийн шалгалтаа амжилттай өгсөн бол элсэлтийн гол шалгуураа хангасанд тооцдог байна.

Финланд улс багшлах авьяас, сонирхолтой оюутныг дараах үе шатаар сонгон шалгаруулж авдаг уламжлалтай. Үүнд:

1. Тухайн оюутны матрикуляцийн (их сургуульд элсэх) шалгалтын онооны дүн
2. Хүүхэдтэй ажилласан туршлага
3. Сурах бичигт суурилсан шалгалт
4. Нийгмийн харилцааны чадвар
5. Ганцаарчилсан ярилцлага

Энэтхэг улсад "Багш мэргэжлээр элсэгчдэд зориулсан сорил" хэмээх А, В, С, D гэсэн 4 хэсэгтэй сорилыг авдаг байна. Сорилын хэсэг тус бүрийн агуулгыг нарийвчилбал,

А хэсэгт тухайн сурагчийн оюун чадварыг үнэлэх даалгавар

В хэсэгт тухайн сурагчийн багшлахуйн ур чадварыг үнэлэх даалгавар

С хэсэгт тухайн сурагчийн ерөнхий мэдлэг болон одоогийн бодит чадварыг үнэлэх даалгавар

D хэсэгт тухайн сурагчийн англи болон хинд хэлний мэдлэг (үгийн сан, хэрэглээний хэлзүй, өгүүлбэрийн бүтэц, уншиж ойлгох)-ийг үнэлэх даалгавар багтдаг байна.

АНУ-д хоёр шатлалтай чадварын шалгалт авч багшийн мэргэжлээр сургадаг ажээ. Чадвар I нь (1) аливаа асуудлын мөн чанар, учир шалтгааныг ухамсарлан ойлгож унших, (2) бүтээлчээр сэтгэн бичих, (3) тоон болон хэмжихүйн ухааны мэдлэгээ

ашиглан хүрээлэн буй орчин, нийгэм-соёлдоо гарч буй ямар нэгэн өөрчлөлтийн мөн чанар, зүй тогтлыг ухаарч ойлгон, өөрийн "амьд" явах үндсэн хэрэгцээгээ хангахуйц ахуйн хэрэглээний нарийн тооцооллыг хийх чадвар гэсэн гурван шалгалтыг багтаадаг.

Чадвар II нь олон төрлийн хичээлийн агуулгыг хамарсан байдаг. Өөрөөр хэлбэл, элсэгч нь өөрийн мэргэшлийн дагуу энэ шалгалтыг өгнө. Уг шалгалт нь (1) багшлахуйн ерөнхий болон тусгай ур чадварыг эзэмшсэн, эсэх, (2) суралцагчийн нас, биеийн онцлогт тохирсон сургалтын арга хэрэглэх сурган хүмүүжүүлэх ур чадварыг эзэмшсэн эсэх, (3) тухайн мэргэжлийн талаарх ерөнхий ба тусгайлсан мэдлэгийг хүүхдэд зааж ойлгуулах чадвар, (4) хөтөлбөр боловсруулах, заавар зөвлөгөө өгөх чадвар зэргийг голчлон үздэг юм байна [3:288-290].

Мөн түүнчлэн багш бэлтгэх сургуульд элсэхийг хүссэн "Мэргэжлийн бэлтгэл хангах шалгалт" буюу хуучнаар бол "Үндсэн чадварын сорил"-ыг өгсөн байхыг шаарддаг байна. Энэ тохиолдолд тухайн сургуульд элсэх өргөдлөө гаргаж болно. Тухайлбал, дунд ангийн багш болохыг хүссэн оюутнуудын хувьд англи хэл, байгалийн ухааны лаборатори хичээл, мэргэжлийн боловсролын бүх хичээлээр, хэрэв тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэших бол физик, бага ангийн багш болохыг хүссэн оюутнууд англи хэл, математик, физик, хими, мэргэжлийн боловсролын бүх хичээлээр тус тус шалгалт өгөх ёстой байдаг.

Эцэст нь тэмдэглэхэд:

Монгол улсад багш мэргэжлээр элсэгчдэд тавих ямар нэгэн шаардлага байдаггүй. Сурагчид элсэлтийн ерөнхий шалгалтын дүндээ дүйцүүлэн багш бэлтгэдэг сургуульд элсэн ордог. Тиймээс элсэгчдийн ихэнх нь өөрийн хүслээр бус, шалгалтын оноо нь таарсан тул орсон байдаг. Мөн сургуульгүй хоцрохгүй тул орохоос өөр аргагүй болох, аав ээжийн шахалтаар орох зэрэг тохиолдлын зүйл их байна. Тодруулж хэлбэл, сайн суралцсан, элсэлтийн шалгалтаар сайн оноо авсан сурагчид багш бэлтгэдэг сургуульд орохгүй байна. Мөн багш болохыг үнэхээр хүссэн сурагчид орох нь тун бага хувийг эзэлж байна. Энэхүү багш бэлтгэдэг сургуулийн элсэлтийн урсгалаар байгаа, тохиолдлоор элсэн ордог явдал бол Монголын ирээдүйн багш нарыг бэлтгэх сургалтын чанарт шууд сөргөөр нөлөөлж байгааг тэмдэглэхгүй өнгөрч болохгүй.

Учир иймийн тулд, Монгол улсад багш бэлтгэх сургуульд оюутан элсүүлэхдээ ямар нэгэн урьдчилсан шаардлага тавьдаг болох хэрэгтэй байна. Ингэхдээ дээр өгүүлсэн боловсролоор тэргүүлэгч улсуудад байдаг багш мэргэжлээр элсэгчдэд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагаас Монголын нөхцөлд тохируулан эхний ээлжинд 1-2 шалгуур тавьдаг болбол сайн

юм. Эхлээд туршилтын журмаар зөвхөн МУБИС-д элсэгчдэд тавих ерөнхий шалгуурыг боловсруулан хэлэлцүүлэх ажлыг эхлүүлэх хэрэгтэй юм.

<http://dx.doi.org/10.1787/9789264xxxxxx-en>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Beena, S. (1995). Determinants of Teacher effectiveness. Ambala Cantt: The Indian Publications, 38-39
- Kaplan, R. M., Saccuzzo, D. P. (2005). *Psychological testing: Principles, applications, and issues* (6th ed.). Belmont, CA: Wadsworth/Thomson.
- Mather, N., Wendling, B.J. (2005). Linking cognitive assessment results to academic interventions for students with learning disabilities. In D. P. Flanagan & P. L. Harrison (Eds.), *Contemporary intellectual assessment: Theories, tests, and issues* (2nd ed., pp. 269–294). New York: Guilford.
- National Advisory Committee for the Ministry of Education and Science (2003), *Attracting, Developing and Retaining Effective Teachers: Country Background Report for Sweden*, Ministry of Education and Science, Stockholm.
- OECD (2012). *Equity and Quality in Education: Supporting Disadvantaged Schools and Students*, OECD Publishing.
- OECD (2010). *Strong Performers and Successful Reformers in Education: Lessons from PISA for the United States*, OECD Publishing.
- OECD (2010). *Educating Teachers for Diversity: Meeting the Challenge*, OECD Publishing.
- OECD (2005). *Teachers Matter – Attracting, Developing and Retaining Effective Teachers*, OECD Publishing.
- Singh, R. P., Sharma, S. N. (1998). *Teaching Aptitude Test Battery*. National Psychological Corporation, Agra (UP), India
- Schleicher, A. (2012). Ed., *Preparing Teachers and Developing School Leaders for the 21st Century: Lessons from around the World*. OECD Publishing.
- Taro NUMAN>教員養成と免許制度, (As of March 2010)
- Teacher Regulation in Germany, Updated on Jan. 09, 2012
- Vyas, R. P. (1982). Relationship of selected factors with the teaching success of prospective teachers of Rajasthan, pp. 48